МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2021 оны 04 сарын 09-ний өдөр Дугаар А/30 Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолоор баталсан Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам, Засгийн газрын 2020 оны 250 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол улсад орчин үеийн шинжлэх ухааны байгууллага байгуулагдсаны 100 жил, Шинжлэх ухааны Академи байгуулагдсаны 60 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын биелэлтийг тогтмол хянаж, хэрэгжилтийн явцыг 14 хоног тутамд тайлагнаж байхыг ажлын хэсэг (академич Б.Авид)-т үүрэг болгосугай.

3. Ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлж, зарцуулалтын төлөвлөгөө гаргаж танилцуулахыг ШУА-ийн Орлогч дарга бөгөөд Санхүү, нийтлэг үйлчилгээний хэлтсийн дарга (Б.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ Д.РЭГДЭЛ

ШУА-ийн Ерөнхийлөгчийн
2021 оны 04 сарын 09-ний
өдрийн А/30 тоот тушаалын
хавсралт

МОНГОЛ УЛСАД СУДАР БИЧГИЙН ХҮРЭЭЛЭН БАЙГУУЛАГДСАНЫ 100 ЖИЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ БАЙГУУЛАГДСАНЫ 60 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Арга хэмжээ	Хугацаа	Хариуцах байгууллага, нэгж, ажилтан
1	Монгол Улсад орчин үеийн шинжлэх ухааны байгууллага үүсэж хөгжсөний 100 жил, Шинжлэх ухааны академи байгуулагдсаны 60 жилийн ойг тэмдэглэх ажлыг зохион байгуулах үүрэг ажлын хэсэг байгуулж ажиллуулах	4 сар	Д.Рэгдэл
2	“Монгол Улсын Шинжлэх ухааны байгууллага – 100 жил” 5 боть ном бүтээж, хэвлүүлэх	1-10 сар	Г.Чулуунбаатар Б.Авид С.Чулуун
3	Шинжлэх ухааны Академийн Хүндэтгэлийн өргөтгөсөн их чуулган зохион байгуулах	5 сар	Г.Чулуунбаатар ЭШХ
4	“Монгол Улсын шинжлэх ухааны байгууллага – 100 жил” баримтат кино бүтээх	4-9 сар	Б.Бат-Эрдэнэ УТХ, ЭШХ, СНҮХ
5	Эрдэм шинжилгээний ажилтан залуусын чуулга уулзалт зохион байгуулах	5-10 сар	Д.Баттогтох
6	Радио, ТВ-ийн нэвтрүүлэг, сошиал орчны түгээн дэлгэрүүлэлт	Жилийн турш	Бүх хэлтсүүд
7	Ойн баярт зориулсан лого, брэнд ном гаргах	4 сар	Д.Батхуяг ИТХ
8	Эрдэм шинжилгээ, судалгаа боловсруулалтын ажлын үр дүнгийн “Шинжлэх ухаан, технологи – 100” үзэсгэлэнг БШУЯ болон ШУТС-тай хамтран зохион байгуулах	11 сар	Б.Сувданцэцэг Бүх хэлтэс Харьяа хүрээлэнгүүд
9	Ойн баярын хурал, ёслолын арга хэмжээ	11 сар	Б.Авид Бүх хэлтэс Харьяа хүрээлэнгүүд
10	Ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг, уулзалт ярилцлагууд зохион байгуулах	8-11 сар	Б.Авид Салбарын Бага чуулганууд Төрөлжсөн академиуд Бүх хэлтэс Харьяа хүрээлэнгүүд
11	Эрдэмтэн судлаачид, ажилтныг шагнаж, урамшуулах ажлыг зохион байгуулах	Жилийн турш	ШУА Харьяа хүрээлэнгүүд
12	Ойд зориулсан спортын арга хэмжээ	10-11 сар	ШУБ-ын ҮЭНХороо
13	Ойн арга хэмжээнд бэлэг, дурсгалын зүйлс бэлтгэх	6-9 сар	Б.Бат-Эрдэнэ СНҮХ

14	2021 онд тохиох түүхэн томоохон ойн арга хэмжээнд оролцох ажлыг зохион байгуулах	Жилийн турш	Харьяа хүрээлэнгүүд
15	Монгол Улсад орчин үеийн шинжлэх ухааны байгууллага үүсэж хөгжсөний 100 жил, Шинжлэх ухааны Академи байгуулагдсаны 60 жилийн ойг тэмдэглэх ажлын төлөвлөгөөг хүрээлэн бүр гаргаж гүйцэтгэлийг хангаж ажиллах	4-11 сар	Харьяа хүрээлэнгүүд

- - - o o 0 o o - - -